


Хүйтний улирал буюу 2012-2015 оны 1-4, 10-12 дугаар сарын  
Улаанбаатар хотын агаарын чанарын төлөв байдал  
**/2014 оны 10-12, 2015 оны 1 дүгээр сарын байдлаар/**

Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчимд агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий ( $\text{SO}_2$ ), азотын давхар исэл ( $\text{NO}_2$ ), том ширхэглэгт тоосонцор ( $\text{PM}_{10}$ ), нарийн ширхэглэгт тоосонцор ( $\text{PM}_{2.5}$ ), нүүрстөрөгчийн дутуу исэл ( $\text{CO}$ ) болон цаг уурын үзүүлэлтүүдийг автомат болон автомат бус багажаар хэмжин тодорхойлсон байна.

Хүйтний улирал буюу 2014 оны 10-12, 2015 оны 1 дүгээр сард агаар дахь агаар бохирдуулах бодисын сарын дундаж агууламжийг 2013, 2014 оны мөн үетэй харьцуулахад том ширхэглэгт тоосонцор **70 мкг-аар буюу 24%-иар**, нарийн ширхэглэгт тоосонцор **17 мкг-аар буюу 13%-иар**, азотын давхар исэл **12 мкг-аар буюу 20%-иар** тус тус **бага**, хүхэрлэг хийн агууламж **2 мкг-аар буюу 6%-иар их** байна.

2012-2015 оны хүйтний улирал (1-4 дүгээр сар, 10-12 дугаар сар)-ын Улаанбаатар хотын агаарын чанарын төлвийг агаар бохирдуулах бодис тус бүрээр дараах зургуудад харууллаа.

**Хүхэрлэг хий ( $\text{SO}_2$ )**




Зураг 1. Хүйтний улирлын хүхэрлэг хийн сарын дундаж агууламж, 2012-2015 он

2014 оны 10-12, 2015 оны 1 дүгээр сарын агаар дахь хүхэрлэг хийн дундаж агууламжийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10-12 дугаар сард ойролцоо түвшинд, 1 дүгээр сард **3 мкг-аар их буюу 5%-иар их** байна. Харин сарын дундаж агууламжийг MNS 4585:2007 Агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээ (цаашид АЧС дахь ХХХ гэх)-тэй харьцуулахад 2014 оны 10-11 дүгээр сард ХХХ-нд байсан бол 12 дугаар сард 2.4 дахин, 2015 оны 1 дүгээр сард 3.4 дахин тус тус их (Зураг 1) байна.

Хүхэрлэг хийн 24 цагийн дундаж агууламжийг 2014 оны 10 дугаар сард нийт 234 удаа хэмжснээс 7%-д, 11 дүгээр сард 202 удаа хэмжилт хийснээс 50%-д, 12 дугаар сард 243 удаа хэмжснээс 94%-д, 2015 оны 1 дүгээр сард 217 удаа хэмжснээс 95%-д нь АЧС дахь ХХХ-ээс давсан тохиолдол ажиглагджээ.

Хүйтний улирлын 2014 оны 10-12, 2015 оны 1 дүгээр сарын 24 цагийн дунджийн хамгийн их агууламж 1-р сард гэр хороолол (1-р хороолол) орчимд 195 мкг/м<sup>3</sup> хүрч АЧС дахь ХХХ-тэй харьцуулахад 9.7 дахин их, өмнөх онд ажиглагдсан 24 цагийн дунджийн хамгийн их агууламжтай харьцуулахад 1.1 дахин бага байна.

### **Том ширхэглэгт тоосонцор (PM10)**




Зураг 2. Хүйтний улирлын том ширхэглэгт тоосонцрын сарын дундаж агууламж, 2012-2015 он

2014 оны 10-12, 2015 оны 1 дүгээр сарын агаар дахь том ширхэглэгт тоосонцор (PM10)-ын сарын дундаж агууламжийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 дугаар сард **3 мкг-аар** буюу **2%-иар**, 11 дүгээр сард **10 мкг-аар** буюу **4%-иар**, 12 дугаар сард **147 мкг-аар** буюу **38%-иар**, 1 дүгээр сард **121 мкг-аар** буюу **32%-иар** тус тус бага байна. Харин сарын дундаж агууламжийг АЧС дахь ХХХ-тэй харьцуулахад 2014 оны 10 дугаар сард 1.7 дахин их, 11, 12 дугаар сард тус бүр 2.3 дахин их, 2015 оны 1 дүгээр сард 2.6 дахин их (Зураг 2) байна.

Том ширхэглэгт тоосонцрын 24 цагийн дундаж агууламжийг 2014 оны 10 дугаар сард нийт 121 удаа хэмжснээс 83%-д, 11, 12 дугаар сард тус бүр 137 удаа хэмжилт хийснээс 89%-д, 2015 оны 1 дүгээр сард 122 удаа хэмжснээс 75%-д нь АЧС дахь ХХХ-ээс давсан тохиолдол ажиглагджээ.

2014 оны 10-12, 2015 оны 1 дүгээр сард 24 цагийн дунджийн хамгийн их агууламж 1 дүгээр сард 100 айл орчимд 1101 мкг/м<sup>3</sup> хүрч АЧС дахь ХХХ-тэй харьцуулахад 11 дахин их, өмнөх онд ажиглагдсан 24 цагийн дунджийн хамгийн их агууламжтай харьцуулахад 1.9 дахин бага байна.

### Нарийн ширхэглэгт тоосонцор (PM2.5)



Зураг 3. Хүйтний улирлын нарийн ширхэглэгт тоосонцрын сарын дундаж агууламж, 2012-2015 он


2014 оны 10-12, 2015 оны 1 дүгээр сарын агаар дахь нарийн ширхэглэгт тоосонцор (PM2.5)-ын сарын дундаж агууламжийг 2013, 2014 оны мөн үетэй харьцуулахад 10 дугаар сард **4 мкг**-аар буюу **8%**-иар их, 11 дүгээр сард **24 мкг**-аар буюу **21%**-иар, 12 дугаар сард **38 мкг**-аар буюу **20%**-иар, 1 дүгээр сард **9 мкг**-аар буюу **5%**-иар тус тус бага байна.

Сарын дундаж агууламжийг АЧС дахь ХХХ-тэй харьцуулахад 2014 оны 10 дугаар сард 1.1 дахин их, 11 дүгээр сард 1.8 дахин их, 12 дугаар сард 2.9 дахин их, 2015 оны 1 дүгээр сард 3.1 дахин их (Зураг 3) байна.

24 цагийн дундаж агууламжийг 2014 оны 10 дугаар сард нийт 62 удаа хэмжснээс 48%-д, 11 дүгээр сард 59 удаа хэмжснээс 76%-д, 12 дугаар сард 60 удаа хэмжилт хийснээс 92%-д, 2015 оны 1 дүгээр сард 59 удаа хэмжснээс 97%-д нь АЧС дахь ХХХ-ээс давсан тохиолдол ажиглагджээ.

Хүйтний улирлын 2014 оны 10-12, 2015 оны 1 дүгээр сарын 24 цагийн дунджийн хамгийн их агууламж Баруун 4 зам орчим 1 дүгээр сард  $436 \text{ мкг/м}^3$  хүрч АЧС дахь ХХХ-тэй харьцуулахад 8.7 дахин их, өмнөх онд ажиглагдсан 24 цагийн дунджийн хамгийн их агууламжтай харьцуулахад 1.6 дахин бага байна.

## Азотын давхар исэл ( $NO_2$ )



Зураг 4. Хүйтний улирлын азотын давхар ислийн сарын дундаж агууламж, 2012-2015 он

2014 оны 10-12, 2015 оны 1 дүгээр сарын агаар дахь азотын давхар ислийн сарын дундаж агууламжийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 дугаар сард **9 мкг**-аар буюу **17%**-иар, 11 дүгээр сард **12 мкг**-аар буюу **21%**-иар, 12 дугаар сард **16 мкг**-аар буюу **24%**-иар, 1 дүгээр сард **11 мкг**-аар буюу **17%**-иар тус тус бага байна.

Азотын давхар ислийн сарын дундаж агууламжийг АЧС дахь ХХХ-тэй харьцуулахад 2014 оны 10 дугаар сард хэвийн, 11, 12 дугаар сард 1.1-1.2 дахин их, 2015 оны 1 дүгээр сард 1.4 дахин их /Зураг 4/ байна.

24 цагийн дундаж агууламжийг 2014 оны 10 дугаар сард нийт 207 удаа хэмжснээс 42%-д, 11 дүгээр сард 199 удаа хэмжилт хийснээс 52%-д, 12 дугаар сард 228 удаа хэмжилт хийснээс 63%-д, 2015 оны 1 дүгээр сард 179 удаа хэмжснээс 71%-д нь АЧС дахь ХХХ-ээс давсан тохиолдол ажиглагджээ.

2014 оны 10-12, 2015 оны 1 дүгээр сарын 24 цагийн дунджийн хамгийн их агууламж Баруун 4 зам орчимд 11 дүгээр сард  $135 \mu\text{g}/\text{m}^3$  хүрч АЧС дахь ХХХ-тэй харьцуулахад 3.4 дахин их, өмнөх онд ажиглагдсан 24 цагийн дунджийн хамгийн их агууламжтай харьцуулахад 1.4 дахин бага байна.

**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**